



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/78

Мандалговь

Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхөд
дэмжлэг үзүүлэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.1 дэх хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай" 02 дугаар албан даалгавар, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, эсэн мэнд амьдрах нөхцөл боломжоор дэмжих, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сайнцагаан сумын Боржигон багийн иргэн Ч.Даваадалайгийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 11, 18-ны өдрүүдэд зохион байгуулж, хяналт тавьж ажилласугай.

2. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхөд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 217890 (Хоёр зуун арван долоон мянга найман зуун ер) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



43119020